



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/08

Жаргалант

Хөтөлбөр боловсруулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.3, дахь заалт, Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.8 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрүүл чийрэг Норовлинчууд” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Д.Шижирмөнх	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	Г.Ариунзул	ЭМТ-ийн эрхлэгч
Гишүүдэд	Э.Ононцэцэг	Санхүү албаны дарга
	Ө.Алтанзул	Цэцэрлэгийн эрхлэгч
	Х.Ууганцэцэг	ЕБС-ийн захирал
	М.Бямбазул	Соёлын төвийн дарга
	Х.Амарбаясгалан	Баян-Өлзийт багийн засаг дарга
	А.Уранчимэг	Ангирт багийн Засаг дарга
	Э.Бат-Орших	Онон багийн засаг дарга
	Г.Оюунчимэг	Жаргалант багийн засаг дарга
	Г.Нямбар	Биеийн тамирын багш
	Г.Хишигбаатар	Биеийн тамирын багш

2.“Эрүүл чийрэг Норовлинчууд” хөтөлбөрийг боловсруулахдаа иргэдийн эрүүл амьдрах дадал зуршлыг олгох зорилтууд дэвшүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхой тусган боловсруулахыг ажлын хэсэг үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ний дотор боловсруулж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232401015